



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/24

Чингис хот

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 29.1.2-ын "а" "б", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 17 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/176 дугаар захирамжийн "3" дахь заалтад Ажлын хэсгийн ахлагчаар Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Дэмбэрэлсайхан гэснийг Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Батсайхан, Хөтлөгчөөр Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн С.Энхцэцэг гэснийг Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн О.Сэдэд, "4" дэх заалтад нээлттэй дуудлагын худалдааг 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр 11:00 цагт Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд зохион байгуулсугай гэснийг нээлттэй дуудлагын худалдааг 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр 11:00 цагт Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд зохион байгуулсугай хэмээн тус тус өөрчлөлт оруулсугай.

2. Эд хөрөнгө худалдах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Л.Батсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010082